



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 345

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө ашиглах хугацаа, үнийг шинэчлэн
тогтоож балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 71,000,000.00 (далан нэгэн сая) төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Булган-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, “Булган-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Э.Пүрэвдэмбэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарын шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 08 дугаар сарын ~~22~~-ны өдрийн
~~315~~ дугаар тогтоолын хавсралт



Гаалийн ерөнхий газрын харьяа Бичигт дэх Гаалийн газрын үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг ашиглах жил үнийг шинэчлэн тогтоож
"Булган-АЗЗА" ТӨХК-д балансаас балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн
жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Балансын, хуrimтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ	Цаашид ашиглах хугацаа
1	Ниссан патрол маркийн, 0019 СҮЭ улсын дугаартай, судлын автомашин, арлын дугаар- JN1TCSY61Z0579 334	2011/2011	71,000,000.00	7,100,000.00	1 жил
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			71,000,000.00 (далан нэгэн сая)	7,100,000.00 (долоон сая нэг зуун мянга)